

ТАНИЛЦУУЛГА

“Олон улсын гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам батлах тухай” Хууль зүй дотоод хэргийн сайд Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаалын төслийн талаар

Монгол Улсын Их Хурал оны дугаар сарын ний өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль Шинэчилсэн найруулга ийг баталж мөн оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтсон.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль Шинэчилсэн найруулга ийн дугаар зүйлийн дахь хэсэгт “Улсын бүртгэлийн байгууллага олон улсын гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага түүний төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу “Олон улсын гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам батлах тухай” Хууль зүй дотоод хэргийн сайд Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаалын төслийг боловсруулан танилцуулж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд олон улсын гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага түүний төлөөлөгчийн газрыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх зохицуулалт шинээр туссантай холбогдуулан журмын төслийг бүлэг заалттайгаар боловсрууллаа.

Журмын төсөлд олон улсын гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага түүний төлөөлөгчийн газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж хөтлөх уг бүртгэлийг хөтлөхөд “Хуулийн этгээд түүний салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам” ыг баримтлах улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргах эрх бүхий этгээд өргөдөлд тавигдах шаардлага хавсаргах баримт бичиг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсныг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан.

Захиргааны ерөнхий хуулийн дугаар зүйлийн дэх хэсэгт заасны дагуу иргэн хуулийн этгээдээс энэ журмын төсөлд санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудаст байршуулсан бөгөөд журмын төсөлд тусгайлан санал ирүүлээгүй болно.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар
хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг
улсын бүртгэлд бүртгэх журам батлах тухай**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн
дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

“Олон улсын гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын
байгууллага түүний төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам” ыг
хавсралтаар баталсугай.

Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын бүртгэлийн
ерөнхий газар Б Баасандорж Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ эрх
зүйн газар А Төмөр т энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль
зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г Билгүүн Гадаад
харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д Даваасүрэн д тус тус үүрэг
болгосугай.

Гарын үсэг

Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Гадаад харилцааны сайдын 2018 оны
... дугаар хамтарсан тушаалын
хавсралт

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРЭЭР БАЙГУУЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

Олон улсын гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага түүний төлөөлөгчийн газар цаашид “Засгийн газар хоорондын байгууллага” гэх ыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхэд энэ журам болон “Хуулийн этгээд түүний салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ыг баримтална.

Засгийн газар хоорондын байгууллагыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж бүртгэнэ.

Хоёр.Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргах эрх бүхий этгээд

Засгийн газар хоорондын байгууллагыг хуулийн этгээдийн улсын **бүртгэлд бүртгүүлэх** өргөдлийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн дэх хэсэг болон олон улсын гэрээ хэлэлцээрт заасан эрх бүхий этгээд гаргана.

Энэ журмын д заасан эрх бүхий этгээд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулсан байна.

Гурав.Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх

Хуулийн этгээдийн улсын **бүртгэлд бүртгүүлэх** өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

- 3.1.1.үүсгэн байгуулсан шийдвэр /тогтоол/;
- 3.1.2.үүсгэн байгуулах баримт бичиг /дүрэм, гэрээ, журам/;
гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөл;
- 3.1.4.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт;
гүйцэтгэх удирдлага эрх бүхий этгээд гадаадын иргэн бол паспортын хуулбар;
- 3.1.6.хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт;
- 3.1.7.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

**Дөрөв.Мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг
хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар хоорондын байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг ажлын 15 өдрийн дотор бүртгүүлнэ.

**Тав.Үйл ажиллагаа дуусгавар болсныг
хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх**

Засгийн газар хоорондын байгууллагын үйл ажиллагаа дуусгавар болсныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

үйл ажиллагааг дуусгавар болгосон тухай эрх бүхий этгээдийн шийдвэр /тогтоол/;

5.1.2.гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний албан бичиг;

5.1.3.татвар төлөгчийн хасалтын карт;
өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа;

5.1.5.тэмдэг хураалгасан баримт;

5.1.6.улсын тэмдэгийн хураамж төлсөн баримт;
улсын бүртгэлийн гэрчилгээ хэрэв үрэгдүүлсэн бол өдөр тутмын сонинд зарлуулсан зар;

5.1.8.хуульд заасан бусад.

Улсын бүртгэгч энэ журмын д заасан өргөдөл баримт бичгийг ажлын өдрийн дотор хянаж үйл ажиллагаа нь дуусгавар болсон Засгийн газар хоорондын байгууллагын мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулж тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна.

Зургаа.Бусад

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой маргааныг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.